



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар

А/217

Мандалговь

"Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар
хийгдэж "Монголын баялаг-330" төслийн
15 сумын видео бичлэг хийх" ажлыг хүлээн
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хийгдэж "Монголын баялаг-330" төслийн 15 сумын видео бичлэг хийх" ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Т.Уранбайгаль	(Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
Гишүүд	М.Бямбажав	(Дундговь аймгийн Музейн захирал)
	Ж.Уянга	(Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Н.Мөнгөн	(Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Хандмаа	(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Х.Цогзолмаа	(Дундговь аймгийн Соёл урлагийн газрын дарга)

2. "Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хийгдэж "Монголын баялаг-330" төслийн 15 сумын видео бичлэг хийх" ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Т.Уранбайгаль)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У. ДОРЖБАТ



4822150495